



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар #1586

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил" болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр захирамжийн хавсралтад тусгагдсан 17 дахь арга хэмжээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бэлчээрийн усан хангамжиг нэмэгдүүлэх инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргахад газрын гүний усны илэрцийг тодорхойлох, хайх багаж худалдан авахад шаардаглах 8,000,000 (найман сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 8,000,000 (найман сая) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

• 011101244

D:My Doc. Zahiramj. Zasag darga